

Шинжлэх ухааны доктор, профессор, Г.Цэрэнбалжидын ургамал судлалын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр



Гончигийн Цэрэнбалжид 1932 онд Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт Улаан айраг хэмээх газар төржээ.

Тэрбээр бага сургуулийн боловсролыг 1939-1943 онд Түдэвтэй суманд, бүрэн бус дунд сургуулийг 1943-1946 онд Жавхлант хотод, дунд сургуулийн Хими-биологийн багшийн мэргэжлийг 1946-1948 онд Улаанбаатарт Багш нарыг бэлтгэх техникумд суралцан багш, 1956-1960 онд МУИС-ийг Биологи-ботаникийн мэргэжлээр төгсжээ. Г.Цэрэнбалжид 1971 онд ЗХУ-д Монгол орны тариалангийн гол нутаг “Орхон Сэлэнгийн сав газрын тариалангийн хог ургамал, тэдгээртэй тэмцэх биологийн үндэслэл” сэдвээр дэд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.


Доктор Цэрэнбалжид Монгол орны тариалан, хадлан, бэлчээр болон хот суурин, буурь, туурь, зам харгуй, үйлдвэр уурхай зэрэг хүн малын хөлд сүйрч, унаган байдлаа алдаж, экологийн гүнзгий эвдрэлд орж байгаа, ургамал, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, ургамлын төрөл зүйлийн усталт, нөхөн сэргэлтийн явцыг 40 гаруй жил судалсан судалгаа сорил шинжилгээнийхээ асар их материалыг боловсруулан, дүгнэж нэгтгэн 1996 онд “Монгол орны хөл газрын ургамал (ангилалзүйн бүрэлдэхүүн, биологи, экологи, географи, гарал үүсэл, үр жимс, үр, аж ахуйн ач холбогдол)” сэдвээр Биологийн шинжлэх ухааны доктор (D.Sc)-ын зэргийг хамгаалсан юм.

Г.Цэрэнбалжид 1948-1955 онд дунд сургуульд хими-биологийн багш, 1955-1956 онд шинжлэх ухааны хүрээлэнд лаборант, 1960-1961 онд Улаанбаатар хотын III арван жилд багшилж байсан. 1961 оны X сараас одоо хүртэл ШУА-ийн эрдмийн хүрээлэнгүүдэд эрдэм шинжилгээний ажилтнаар 52 жил тасралтгүй ажиллаад, одоо гавьяаны амралтаа эдэлж сууна.

Г.Цэрэнбалжид монгол орны хөл газрын ургамлын ангилал зүйн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, морфологи, экологи болон ургамал-газарзүй, ареал, гарал үүслийн холбогдолт онолын судалгааны зэрэгцээ хор хөнөөл, хорио цээрийн байдлыг тус тус судалж эрдмийн ажлын үр дүнгээ нэгтгэн дүгнэж, онол, практикийн ач холбогдолтой эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл 7, товхимол 2, сурах бичиг 1, өгүүлэл 52 туурвин нийтлүүлсэн бүтээлүүд нь бүхэлдээ манай орны газар тариалан, хадлан бэлчээртэй холбогдсон, тэдгээрийн өгөөжийг нэмэгдүүлэхэд хөл газрын ургамалтай харьцах, тэмцэх, ашиглах боломжуудыг тодорхойлсон, бодлогын чанартай асуудлуудыг гаргаж тавьсан онцлогтой.


Доктор Г.Цэрэнбалжид шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлдээ Монгол орны хөл газрын ургамал, тэдгээрийг байгальд бусад ногоон ургамлын нэгэн адил ээлтэй, дэлхийн амьдралын мөнхийн бүрхүүлийн үүргийг гүйцэтгэн экосистемийн хэвийн хам бүрдлийг хамгаалан, сэргээх үндсэн нөхцөлийг урьдчилан бүрдүүлэх хосгүй үйлдэлтэй байгалийн шархыг эдгээх, өөрийнх нь био нөхөөс түүний нөхөн төлжилтийг эхлэн гүйцэтгэгч ууган ургамлууд гэсэн гүнзгий агуулгатай дүгнэлт хийжээ. Энэ бүтээлдээ монгол орны хөл газрын 438 зүйл ургамлын дотор хүнсэнд хэрэглэгддэг 72, балт ургамал 123 байгаагаас I зэргийн балтай 33, II зэргийн балтай 40 зүйл, 246 зүйл нь эмийн ургамал, фитонцидтэй 50 зүйл, будагч бодистой 16 зүйл, утас олсны ширхэгт 5, сайн чанарын цаас хийдэг 3, содтой 7, гоёл чимэглэлийн 45, бүх биедээ иодтой 1 зүйл ургамал байгаагаас гадна хөл газрын бүх ургамлын 176 (40.2%) зүйл нь мал, шувуу, гахайн тэжээлийн үнэт ургамал болохыг тодруулж. Ийнхүү тэдгээрийг хаяанаасаа түүн ашиглах “био-хуанли” зохиосон болно.

Г.Цэрэнбалжид судалгааны үр дүнгүүддээ үндэслэн хөл газрын ургамалтай байгаль орчны нөхөн сэргэлт болон амьдрал ахуйдаа ашиглах замаар тэмцэх гэсэн бодлогын чанартай сонирхолтой санааг дэвшүүлсэн билээ.



Доктор Г.Цэрэнбалжид 2002 онд хэвлүүлсэн “Монгол орны, хөл газрын ургамлын өнгөт цомог” бүтээлдээ хөл газрын 173 зүйл ургамлыг өнгөт зургаар нь үзүүлэн тэдгээрийн эко-био-морфологи шинж байдалд тодорхойлолт өгсөн. Энэхүү бүтээл хөдөө аж ахуй, газар тариалангийн бүх шатны мэргэжилтнүүдийн ширээний ном, гарын авлага болжээ.


Доктор Г.Цэрэнбалжид эрдэм шинжилгээний бүтээлүүдээрээ боловсрол сургалтын салбарт байнга оролцож, түүний тариалангийн хог ургамлын тухай нэгэн сэдэвт ном бүтээл, сурах бичиг зэрэг нийтлэлүүд нь ХААИС-д 1961 оноос өдгөө хүртэл сургалтын хэрэглээ болсоор байна.



Профессор Г.Цэрэнбалжид 1971 оноос эхлэн УБИС, ХААИС, МУИС-д тасралтгүй багшлан оюутны курс, диплом, магистрын ажлыг удирдаж ажилладаг сурган хүмүүжүүлэгч төдийгүй, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд зориулан Монгол орны байгалийн болон хөл газрын 230-340 зүйл ургамлын цуглуулгыг УБИС, ХААИС-ын холбогдох тэнхимүүдэд шилжүүлжээ. Түүнчлэн Монгол орны гуурст ургамлын үр жимс, үрийн биет альбомыг холбогдох танилцуулга, зааврын хамт УБИС-ийн Биологийн тэнхимд 2001 онд шилжүүлсэн юм.

Доктор Г.Цэрэнбалжид шинжлэх ухааны байгууллагад ажилласан хугацаандаа газар тариалангийн үйлдвэрлэл, бэлчээр ашиглалт ба хотын ногоон байгууламжийн хог ургамлын зурагт цомог, тэдгээртэй тэмцэх

био-экологийн үндэслэл зөвлөмжийг Дархан, Ингэттолгой, Улаантолгой, Жаргалантын сангийн аж ахуй, Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэх трестэд, Төв аймгийн Баян сум Булган аймгийн Хангал сумын ургамлан нөмрөгийн 1:100 000 маштабтай зургууд, Баянхонгор аймгийн Өлзийт, Баацагаан, Баянцагаан, Бууцагаан, Жинст, Хүрээмарал, Баян-Өндөр сумуудын бэлчээрийн 1:100000 маштабтай зургуудыг үйлдэж, дурсан сумуудын нутагт тархсан гуурст ургамлын ангилалзүйн бүрэлдэхүүний бүрэн жагсаалтын хамт бэлчээр ашиглахад гарын авлага болгох зорилгоор шилжүүлжээ. 1999 онд Архангай, Сүхбаатар аймгууд, Улаанбаатар орчмын хадлан, газар тариалангийн талбайн эко-ботаникийн байдлыг хянан баталгаажуулж зурагласан ажлуудыг ургамлын жагсаалтын хамт холбогдох газруудад нь шилжүүлсэн юм.



Доктор, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, шинжлэх ухааны тэргүүний ажилтан цолтойгоор Г. Цэрэнбалжидын ажил, үйлс бүтээл бүхэлдээ Монгол орны байгаль орчныг хамгаалах, сэргээхэд зориулагдсаны дотор, тэрээр Монгол орны ургамлын аймагт гадаад ба дотоодхориоцээртэй элементүүдийг гаргаж нийтлүүлсний зэрэгцээ ургамал хамгаалах чиглэлээр тариалангийн хог ургамалтай тэмцэх өвөрмөц, байгаль орчинд аюулгүй ургамлын биологи-экологийн үндэслэлтэй бодлого боловсруулсан юм. Монголд “Тахь” нутагшуулах ажилд биеэр оролцож, Тахийн тал орчмын ургамал, ургамлан нөмрөгийг судалсан эрдэмтэн.

Доктор Г.Цэрэнбалжид Монгол орны экосистемийн хувьсал өөрчлөлтийг түүний үндсэн нэгдэл хэсэг болох ургамал, хөрсний талаас нь нарийвчлан судалж, судалгаа шинжилгээний ажлынхаа нэг хэсгийг монгол орны байгалийн ургамлын удмын санг хамгаалах асуудалд чиглүүлэн тэдгээрийн үр жимс, үрийн биологи, физиологи, морфологи, экологийг судалж, Монгол орны байгалийн 553 зүйл ургамлын үрийн цуглуулгын сан байгууллаа. Доктор Г. Цэрэнбалжидын удирдсан байгалийн ургамлын үр жимс, үрийн судалгааг эх ургамлынх нь эмбриологи, эд эсийн бүтэц, кариологийн онцлогтой нь холбон судлах эрдэм шинжилгээний ажлууд Ургамлын анатоми-физиологийн лабораторид эрчимтэй явагдаж байна.

Г. Цэрэнбалжидын 40 гаруй жил гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээний бүтээлч үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүн бүхэлдээ Монгол улсын Хөдөө аж ахуйн үндсэн салбар газар тариалан, мал аж ахуй, бэлчээр тэжээлийн асуудалд зориулагдан, эрдэм шинжилгээний бүтээлүүд нь ХАА-н салбарын мэргэжилтэн, удирдах ажилтан, хорио цээрийн албаны ажилтан нарт гарын авлага ширээний ном болон ашиглагдаж байгаа төдийгүй, газар тариалангийн мэргэжилтэн бэлдэх бүх шатны сургууль, курс, дамжааны багш, оюутан, сурагчдад сурах, сургах хэрэглээ болсоор байна.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн
Ургамлын ангилалзүй, фиологенетикийн лабораторийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) Н.Амартүвшин